



**МОНГОЛ УЛСЫН
ҮНДЭСНИЙ БАТЛАН ХАМГААЛАХЫН
ИХ СУРГУУЛИЙН ЗАХИРЛЫН
ТУШААЛ**

2026 оны 05 сарын 15 өдөр

Дугаар A/295

Улаанбаатар хот

Энгийн ажлын байранд сул орон тоонд
нээлттэй сонгон шалгаруулалт явуулах
журам батлах тухай

Дээд боловсролын тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1.2 Батлан хамгаалахын сайдын 2025 оны А/381 дүгээр тушаалаар батлагдсан “Үндэсний батлан хамгаалахын их сургуулийн дүрэм”-ийн 11.7.1, 11.7.8, их сургуулийн захирлын 2026 оны А/138 дугаар тушаалаар батлагдсан “Хөдөлмөрийн дотоод журам”-ын тушаалын 3.1, 3.2 дахь заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. “Энгийн ажлын байрны сул орон тоонд нээлттэй сонгон шалгаруулалт явуулах журам”-ыг хавсралтаар баталсугай.

2. Журмыг хэрэгжүүлж ажиллахыг Цэргийн алба, захиргааны удирдлага хариуцсан дэд захирал (хурандаа О.Жамбажамц)-д хариуцуулсугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавихыг Дотоод аудит, чанарын үнэлгээний алба (дэд хурандаа Э.Батгэрэл)-д даалгасугай.

ЗАХИРАЛ
БРИГАДЫН ГЕНЕРАЛ

Т.БУЯНБАТ



1326010745



پسندیدہ میسرہ میں اعلیٰ درجہ کی تعلیم اور تعلیمی سہولتوں کے
کے ساتھ ساتھ تعلیم کے ذریعہ سے تعلیم کے ذریعہ سے

۲۵۰۳ یسر و ۱۵۰ یس نام گاه یقین

فصل ۲۲

پیشکش کنندہ

بِسْمِ اللَّهِ الرَّحْمَنِ الرَّحِيمِ
 الْحَمْدُ لِلَّهِ الَّذِي
 بَدَأَ الْخَلْقَ وَإِلَيْهِ
 الْمَصِيرُ

[illegible]

6 .. >> ((سا بعدد سعد مر ويخندم به بصير اعظم بعنفس في نيلين بيقين مصنفهم بجيشكستيمصيفر كوتتمبوق الحزم)) -
به يسورمصيفر وير وفيصيرمتين ..

۷) الحکم از اینست که حق تعالی در حکم مردم سبقت، دادگستری را بر همه مقامات و دستگاهها ترجیح داده است. (مجلس، در بیان عقاید، ص ۱۰۰)

۱۱. (وقعتی خبر) - ۱۲. سائنسی پیشرفتیں

ۛ، ۛۛۛۛۛۛ

سریتم و مختلف مر رختی



1326020468

Үндэсний батлан хамгаалахын
их сургуулийн захирлын
2020. оны 15. дугаар сарын 15. -ны
өдрийн 15. дугаар тушаалын
хавсралт



ҮНДЭСНИЙ БАТЛАН ХАМГААЛАХЫН ИХ СУРГУУЛЬД АЛБА ХААГЧИДЫГ СОНГОН ШАЛГАРУУЛАХ ЖУРАМ

1.1 Энэхүү журмын зорилго нь Үндэсний батлан хамгаалахын их сургууль (цаашид их сургууль гэх)-д тогтвор суурьшилтай, үр бүтээлтэй ажиллах ажилтан сонгон шалгаруулах, сонгон шалгаруулалтай холбоотой харилцааг зохицуулахад оршино.

1.2 Их сургуулийн тайван цагийн орон тооны дагуу ажилтныг сонгон шалгаруулахад энэхүү журмыг заавал баримтлах бөгөөд заагдсан шаардлагыг харгалзан шууд томилох ба журамд заасны дагуу сонгон шалгаруулж болно.

Нэг. Ажилтанд тавигдах шаардлага

- 1.1.Тухайн албан тушаалд тохирсон боловсролын зэрэгтэй байх;
- 1.2.Мэдээллийн техник, хэрэгслийг хэрэглээний түвшинд бүрэн эзэмшсэн байх;
- 1.3.Тухайн ажлын байр, албан тушаалын тодорхойлолтод заагдсан шаардлага хангасан байх;
- 1.4.Төрийн алба хаагчийн ёс зүйн хэм хэмжээг сахин биелүүлдэг байх;

Хоёр. Сонгон шалгаруулалт

2.1. Шалгалт зохион байгуулах байнгын комиссын үйл ажиллагаа.

2.1.1.Сонгон шалгаруулах комиссыг Захиргааны удирдлагын хэлтсийн Хүний нөөцийн тасгийн бүрэлдэхүүнийг оруулан захирлын тушаалаар батална.

2.1.2.Шаардлагатай гэж үзвэл сонгон шалгаруулалтын комисст тухайн чиглэлийн мэдлэг, туршлагатай албан тушаалтныг оролцуулж болно.

2.1.3.Комисс нь сонгон шалгаруулалтай холбоотой аливаа асуудлыг хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэх ба тухай бүрд нь хуралдааныг бэлтгэх, зохион байгуулах ажлыг байнгын комиссын нарийн бичгийн дарга хариуцан зохион байгуулна.

2.1.4.Сонгон шалгаруулалт явуулах шалгалтыг ажлын байр тус бүрээр шалгалтын материалыг бэлдүүлэн нууцлалыг хангах асуудлыг томилогдсон комисс хариуцах ба сонгон шалгаруулалттай холбоотой маргааныг эцэслэн шийдвэрлэнэ;

2.2. Сонгон шалгаруулалтын зар

2.2.1.Ажилтны сул орон тоонд ажилтан шалгаруулах саналыг бэлтгэн Цэргийн алба, захиргааны удирдлага хариуцсан дэд захирал, Захиргааны удирдлагын хэлтсийн дарга зөвшөөрсөн тохиолдолд Захиргааны удирдлагын хэлтсийн Хүний нөөцийн нэгж хариуцан зар тавина.

2.2.2.Зарыг сонгон шалгаруулалт явуулахаас 30-аас доошгүй хоногийн өмнө тус их сургуулийн web, facebook хуудас болон бусад хэвлэл, мэдээллийн хэрэгслээр зарлана.

2.2.3.Зарын агуулгад ажлын байрны нэр, албан тушаалын зэрэглэл, тавигдах ерөнхий шаардлага, ажлын байрын тоо, бүрдүүлэх баримт бичиг, материал хүлээн авах хугацаа, лавлагаа мэдээлэл өгөх албан тушаалын утасны дугаар, материал хүлээн авах хаяг, байршил зэргийг товч ойлгомжтой байдлаар тусгана.

2.3. Бүртгэл

2.3.1.Бүртгэлийг комиссын нарийн бичгийн дарга зар тавигдсан хугацаанд бүртгэж, материалын бүрдлийг шалгаж, оролцогч бүрд дүнгийн хуудас /хавсралт-1/ хөтөлсөн байна.

2.3.2.Сонгон шалгаруулалтад оролцогчдоос дараах материал бүрдүүлсэн байна.

- Ажилд орохыг хүссэн өргөдөл;
- Төрийн албан хаагчийн анкет;
- Боловсролын зэргийг гэрчилсэн баримт /диплом/-ын хуулбар /E-Mongolia/;
- Эрүүл мэндийн магадалгаа;
- Оршин суугаа хорооны болон цагдаагийн байгууллагын тодорхойлолт /E-Mongolia/;
- Иргэний үнэмлэхийн хуулбар /E-Mongolia/;
- Цээж зураг 2 хувь (3 x 4);
- Бусад шаардлагатай бичиг баримт.

2.4 Сонгон шалгаруулалтын шалгалтын төрөл, хэлбэр

2.4.1. Шалгаруулалт нь дараах хэсгээс бүрдэнэ.

- Ерөнхий болон мэргэжлийн мэдлэгийн түвшин тогтоох шалгалт
- Ур чадварын түвшин тогтоох шалгалт
- Гадаад хэлний шалгалт
- Мэдлэг, хандлага, зан үйлийг тодорхойлох ярилцлага

2.5.Ерөнхий (боловсрол, шинжлэх ухааны болон төрийн албаны тухай хууль эрх зүйн мэдлэг) болон мэргэжлийн мэдлэгийн шалгалтыг бэлтгэсэн тест хэлбэрээр авч шалгаруулна.

2.6.Ур чадварын түвшин тогтоох шалгалтыг өрсөлдөгчдөөс тодорхой сэдвүүдээр эсээ бичүүлэх хэлбэрээр тус тус зохион байгуулна. Мөн комиссын зүгээс өөр хэлбэрээр /эсээ бичүүлэх, орчуулга хийлгэх, богино ярилцлага хийх гэх мэт/ шалгалт авч болно.

2.7.Гадаад хэлний шалгалтыг англи, орос эсвэл шалгуулагчийн сайн эзэмшсэн хэлээр шалгалт авах ба англи, орос хэлний хүлээн зөвшөөрөгдсөн шалгалтын оноотой бол түүнийг орлуулан тооцож болно.

2.8.Мэдлэг, хандлага, зан үйлийг тодорхойлох ярилцлагын шалгалтыг хүснэгтийн дагуу /хавсралт-2/ тусгай бэлтгэсэн асуултаар болон гишүүдийн сонгосон сэдвээр харилцан ярилцах замаар оноо өгч шалгаруулна.

2.9.Сонгон шалгаруулалтыг явуулахдаа дээрх шалгалтын дарааллыг баримтлах ба ерөнхий болон мэргэжлийн түвшин тогтоох шалгалтын босго оноо хангаж тэнцсэн иргэнийг ур чадварын, энэхүү шалгалтын оноог хангаж тэнцсэн

иргэнийг гадаад хэлний, энэхүү шалгалтын босго оноог хангасан иргэнийг мэдлэг хандлага, зан үйлийг тодорхойлох ярилцлага шалгалтуудад оруулна
 2.10.Комисс дүнг цаг тухайд нь оролцогчид мэдэгдэн, дүнгийн хуудас /хавсралт-3/-ыг хөтөлнө.

Гурав. Сонгон шалгаруулалтын дүн гаргах, баталгаажуулах

3.1.Комисс нь 3 дахь шатны шалгалтад хамгийн өндөр оноо авсан 2 болон түүнээс дээш албан хаагчдыг сонгон шалгаруулахдаа ойролцоо оноотой бол "Мэдлэг, хандлага, зан үйлийг тодорхойлох" шалгалтын оноог чухалчлан үзнэ.

3.2.Эцсийн шийдвэрийг онооны дарааллыг үндэслэн комиссын бүрэлдэхүүний олонхын саналаар батлан шийдвэрлэнэ

3.3.Шийдвэрийг оролцогчид танилцуулан, сонгон шалгаруулалтын дүнгийн хуудсыг танилцуулж гарын үсэг зуруулна.

3.4.Комиссын шийдвэр гарч, тэнцсэн иргэнийг албан тушаалд нэр дэвшүүлэх саналыг холбогдох материалын хамт ажлын 5 өдөрт багтаан Захиргааны удирдлагын хэлтэст ирүүлнэ.

3.5.Сонгон шалгаруулалтад тэнцсэн иргэн, алба хаагчийг захиргааны зөвлөлийн хурлаар хэлэлцэх ба албан тушаалд томилох үйл ажиллагааг байгууллагын хөдөлмөрийн дотоод журамд заасны дагуу зөвлөлийн гишүүдийн олонхын саналаар эцэслэн шийдвэрлэнэ.

ҮНДЭСНИЙ БАТЛАН ХАМГААЛАХЫН ИХ СУРГУУЛЬ

СОНГОН ШАЛГАРУУЛАЛТЫН ДҮНГИЙН ХУУДАС

НЭГ. ОРОЛЦОГЧ

Овог, нэр:.....

Регистрийн дугаар:.....

ХОЁР. АЖИЛЛАХЫГ СОНИРХОЖ БУЙ

Төв:.....

Албан тушаал:.....

ГУРАВ. ШАЛГАЛТЫН ДҮН

№	Шалгалтын төрөл	Шалгалт өгсөн огноо	Авбал зохих дээд оноо	Авсан оноо
1.	Ерөнхий ба мэргэжлийн түвшин тогтоох шалгалт			
2.	Ур чадварын шалгалт			
3.	Гадаад хэлний шалгалт			
4.	Мэдлэг, хандлага, зан үйлийг тодорхойлох шалгалт			

ДҮНТЭЙ ТАНИЛЦСАН:.....

/гарын үсэг, нэр/

БАЙНГЫН КОМИССЫН ДАРГА:.....

/гарын үсэг, нэр/

ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ХЭЛТЭС

**МЭДЛЭГ, ХАНДЛАГА, ЗАН ҮЙЛИЙГ ТОДОРХОЙЛОХ ШАЛГАЛТЫН
ДҮНГИЙН ХҮСНЭГТ**

№	Үзүүлэлт	Ажлын хэсгийн гишүүдийн үнэлгээ			Дундаж оноо
		1 дэх гишүүн	2 дахь гишүүн	3 дахь гишүүн	
1.	Ажиллах байгууллага, төв, ажлын байрны зорилго, зорилт чиг үүргийн талаарх ерөнхий төсөөлөл				
2.	Батлан хамгаалах салбарын бодлого, зорилт, цэргийн боловсрол, ШУ-ны талаарх ерөнхий мэдлэг				
3.	Тухайн албан тушаалыг хашихад шаардлагатай мэдлэг, туршлага				
4.	Тухайн албан тушаалыг хаших сонирхол, эрмэлзэл хандлага				
5.	Зан байдал, багаар ажиллах, баг бүрдүүлэх чадвар				
НИЙТ ҮНЭЛГЭЭ					

Үнэлгээний шатлал: Маш сайн-4, Сайн-3, Дунд-2, Хангалтгүй-1 оноо

ДҮГНЭСЭН:

1 ДЭХ ГИШҮҮН:/огноо/.....

2 ДАХЬ ГИШҮҮН:/огноо/.....

3 ДАХЬ ГИШҮҮН:/огноо/.....

ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ХЭЛТЭС